

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2024 оны 12 дугаар сарын 18

Багануур дүүрэг


д/д	Зорилт	№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
1.		1.1.1	Паркийн эрх зүйн байдлын хуулийн хүрээнд БҮТП-ийн хуулийн статус өөрчлөх асуудлыг НЗДТГ-т танилцуулах	<ul style="list-style-type: none"> ▪ 2024.03.25ны өдрийн Нийслэлийн ИТХ-ын 37 дугаар тогтоолоор “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын хуулийн хэлбэрийг өөрчлөн “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” (хаалттай) Хувьцаат компани болгож, дүрмийг баталсан. ▪ 2024.07.31ны өдрийн албан бичгээр НӨХГ-ын дарга В.Оюумаад БҮТП ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)–ийг 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулах саналыг НИТХ-д уламжлан шийдвэрлүүлэх хүсэлт илгээсэн. ▪ 2024.12.04-ний НИТХ-н 24/17 дугаар тогтоолоор БҮТП ХК-н 6 гишүүний бүрэлдэхүүнтэй ТУЗ байгуулагдаж, дэвшүүлсэн зорилт бүрэн хэрэгжсэн. 	100
2.	1.1 Паркийн удирдлага, засаглалыг төгөлдөржүүлнэ	1.1.2	Стратегийн удирдагчийн манлайлалыг хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Паркийн удирдлагын зүгээс Стратеги төлөвлөгөө, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлант онд боловсруулан баталсан дотоод үйл ажиллгааны хөтөлбөрүүдийн биелэлтийг хангахад байгууллагын хамт олныг өндөр түвшинд зохион байгуулан, бүтээмжийг зорилтот түвшинг хангахад чиглүүлэн, бүх талын дэмжлэг үзүүлж ажилласан. • Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд гадаад дотоод харилцаанд онцгой анхаарч, Герман, Казахстан, Хятад улсын төрийн болон хувийн хэвшлийн байгуулагуудтай харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах 2 санамж бичиг байгуулж, хэрэгжилтийг хангахад манлайлан ажиллаж үр дүнд хүрч бөайна. • Паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахад анхаарч, зарим батлагдаагүй журам, дүрмийг боловсруулах асуудлыг НЗД, АҮЭБЯ, ЗГХЭГ-т удаа дараа тавьж, улсын хэмжээнд байгуулах хүнд аж үйлдвэрийн паркуудын байршилыг хэлэлцүүлэхэд оролцож БҮТП-ыг нүүрс-химийн үйлдвэрлэлийн салбарын байршилд батлуулж, мөн УИХ-ын АҮБХ-нд ҮТП-ийн хөгжлийн явцын тухай сонсголд оролцож, тулгамдсан асуудлуудаар тодорхой байр суурийг илэрхийлэн, тус байнгын хорооноос байгуулсан ажлын хэсэгт сонгогдон ажиллаж байна. • Төрийн байгууллагын удирдагчийн хувьд Монгол улсын үндсэн хууль, бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтийг байгууллагын болон гадаад, дотоод харилцаанд чанд ханган, ямар нэгэн ашиг сонирхол болон гэмт хэргийн зөрчилгүй манлайлалыг баримтлан ажиллаж байна. 	100

3.		1.1.3	<p>"Багануур үйлдвэрлэл технологийн парк"-ийн бодлогын баримт бичгийг салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд дэвшүүлсэн төр засгийн бодлого, шийдвэр, парктэй холбоотой хууль тогтоомж, эрх зүйн акт, дүрмээр тогтоосон чиг үүрэгтэй уялдуулах</p>	<p>Паркийн бүх төрлийн бодлогын баримт бичгүүд нь дүрмээр хүлээсэн 11 чиг үүрэг болон дараах төр засгийн бодлого шийдвэртэй уялдуулан үүрэг болгон ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль ▪ Газрын төлбөрийн тухай хууль ▪ Үл хөдлөх албан татварын тухай хууль ▪ Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль ▪ Монгол Улсын Алсын Хараа - 2050 ▪ Монгол Улсын Шинэ Сэргэлтийн Бодлого ▪ МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө ▪ Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл ▪ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр ▪ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр ▪ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө ▪ Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл ▪ Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө ▪ Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө ▪ Багануур дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэгт уялдуулан боловсруулан, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаа. 	100
4.		1.1.4	<p>Парк-Суралцагч байгууллага байх үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу үргэлжлүүлэх, ажилтнуудыг мэргэшүүлэх, идэвхжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар дарга паркийн эзэмшилд байдаг хуучин барилгыг "Паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв" болгон ашиглах чиглэл өгч зардал, санхүүгийн тооцоо судалгаа гаргах үүрэг өгсөний дагуу НӨХГ-тай хамтран судалгаа, үнэлгээ хийсэн бөгөөд 2024.11.11-ны өдрийн 03/6378 дугаар албан бичгээр Паркийн Захиргаа нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын засварын ажлыг "Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний 231 дэх заалтад тусган НИТХ-ын 2024 оны 134 дүгээр тогтоолоор батлуулж 2025 онд 60% гүйцэтгэлтэй хэрэгжүүлэх зорилтын дагуу 1,740.0 сая төгрөгийн санхүүжилтийг Нийслэлийн төсвийн төсөлд тусган, өргөн мэдүүлэхээр бэлтгэл ажил хангагдан хүлээгдэж байна. Энэхүү төсөв батлагдсанаар албан хаагчдын ажиллах тав тухтай орчин нөхцөл дээшлэх эхлэл болж байна. ▪ Байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөөг 4 зорилт 17 арга хэмжээтэйгээр батлуулж хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан. 	100

				<ul style="list-style-type: none"> Байгууллагын албан хаагчдын сургалтын 2024 оны төлөвлөгөөг 3 зорилт 21 арга хэмжээтэйгээр батлуулж хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан. 	
5.			Хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн санг хөгжүүлэх, цахимжуулах	<ul style="list-style-type: none"> Төрийн албаны Хүний Нөөцийн Удирдлага Мэдээллийн Тогтолцоо (ХНУМТ) цахим системд албан хаагчидын мэдээллийг тогтмол шинэчилж, шилжилт хөдөлгөөнийг бүртгэн цахим системийн бүртгэлийг бүрэн хариуцаж ажилласан. Тайлант онд ажилтан ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтан, шинээр ажилд орсон 1 ажилтан байна. 	100
6.	1.2 Паркийн хөгжлийг хангахуйц хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ.	1.2.1	Паркийн хүний нөөцийн бүтэц, зохион байгуулалтанд дүн шинжилгээ хийн шинэчлэн боловсруулах, албан тушаалын чиг үүрэг, уяалдаа холбоог нягтаршуулах,	<ul style="list-style-type: none"> Төрийн албан хаагчдын зэрэглэл, ангилалд өөрчлөлт орж цалин нэмэгдсэнтэй холбогдуулан байгууллагын "Бүтэц, орон тоо, чиг үүрэг, цалингийн сүлжээ батлах тухай" А/07 дугаар тушаалыг 2024.04.09-ны өдөр албажуулан гаргаж Төрийн албаны зөвлөлийн "Хүний нөөцийн удирдлага мэдээллийн систем"-ын мэдээллийн санд албан хаагчдын мэргэжлийн нэршил, цалингийн өөрчлөлт, зэрэглэлийн өөрчлөлт нийгмийн даатгалын код зэргийг шинэчилэн бүртгэсэн. Бүтэц зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэн дараах 5 албан тушаалд дотоод албан хаагч нартаа хавсран гүйцэтгүүлэхээр тушаал гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. <ul style="list-style-type: none"> 2024.04.09-ны өдрийн Б/02 тушаалаар Хуулийн зөвлөх С.Отгонбаатар - Хот хариуцсан төлөөлөгч албан тушаалыг хавсран гүйцэтгэх 2024.04.09-ны өдрийн Б/03 тушаалаар Гадаад харилцаа, бичиг хэрэг, архив хариуцсан мэргэжилтэн М.Мөнхдулам - Маркетинг олон нийтийн харилцааны үйл ажиллагаа албан тушаалыг хавсран гүйцэтгэх 2024.04.09-ны өдрийн Б/004 тушаалаар УТА-ны ахлах мэргэжилтэн Б.Мөнгөнхуяг - ХЕТөлөвлөлтийн инженер албан тушаалыг хавсран гүйцэтгэх 2024.04.09-ны өдрийн Б/05 тушаалаар Б.Зоригт - Эрдэм шинжилгээ судалгааны төвийн конструктор инженер албан тушаалыг хавсран гүйцэтгэх 2024.04.09-ны өдрийн Б/06 тушаалаар С.Энхбат - Дэд бүтцийн инженер албан тушаалыг хавсран гүйцэтгэх 	100
7.		1.2.1 3	Нийт албан хаагчдын оролцоотой Байгууллагын бодлогын баримт бичиг, үндсэн үйл ажиллагааны чиглэл, салбар зөвлөлийн үйл ажиллагаа, бүх шатны үүрэг даалгаварын хэрэгжилт, ажлын биелэлт зэрэгт хяналт шалгалт	<p>Паркийн хүрээнд хэрэгжиж буй хууль, эрх зүйн акт, тогтоол шийдвэр болон яам, нийслэл, дүүргээс хэрэгжүүлж буй бодлогын баримт бичгүүдийн холбогдох заалтуудыг барин үндсэн үйл ажиллагааг явуулан ажилласан бөгөөд сар, улирал, хагас бүтэн жилээр тайлан биелэлтүүдийг гарган хамт олны хурлаар хэлэлцэн дараа дараагийн үйл ажиллагаануудыг төлөвлөн ажилласан. Тайлант онд дараах бодлогын баримт бичгүүдийг барьж ажиллан бүрэн хэрэгжүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> Монгол Улсын Алсын Хараа - 2050 	100

			хийх ажлыг улирал тутам зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын Шинэ Сэргэлтийн Бодлого МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө Багануур дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө <p>Мөн байгууллагын хэмжээнд дараах салбар зөвлөл, комисс ажиллаж бүрэн хангалттай хэрэгжилттэй байна.</p> <ul style="list-style-type: none"> Баримт бичиг нягтлан шалгах комисс Дотоод хяналт шалгалтын комисс Байгууллагын өмч хамгаалах байнгын комисс Гэр бүл, хүүхэд, залуучуудын комисс Даргын зөвлөл Ёс зүйн зөвлөл Спорт эрүүл мэндийн салбар зөвлөл Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб 	
8.	1.3 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах	1.3.1	Дээд газрын тогтоол, шийдвэрээс өөрийн байгууллагад холбогдох заалтуудыг хяналтад авах	2024 онд дараах тогтоол, шийдвэрүүдийг нэмэлтээр хяналтад авч бүртгэн хэрэгжүүлж, улирал бүр тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан мэдээг хүргүүлж ажилласан. Үүнд:	100
9.		1.3.2	Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь зохион байгуулж даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байх	<ul style="list-style-type: none"> Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны "Нийслэл Улаанбаатар хотын 385 жилийн ойг тэмдэглэх тухай" 105 дугаар тогтоол Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 2024 оныг "Тохижилт бүтээн байгуулалтын жил" болгон зарлах тухай А/01 дүгээр захирамж МУ-ын Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн "2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай" албан даалгавар Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны ажил дүгнэх тухай" А/349 дүгээр захирамж 	100
10.		1.3.3	Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамж, Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын өөрийн байгууллагад холбогдох заалтыг хяналтад бүрэн авч карт хөтлөн бүртгэлжүүлэх,		100

		биелэлтийг гарган даргын зөвлөлийн танилцуулсан байна.	<ul style="list-style-type: none"> Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө батлах тухай" А/352 дугаар захирамж Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн "Орчны бохирдлыг бууруулах, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ, хог хаягдлын менежментийг сайжруулах тухай" А/424 дүгээр захирамж Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн "Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам" А/465 дугаар захирамж Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн "Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай" А/630 дугаар захирамж УИХ-ын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" 46 дугаар тогтоол 	
11.	1.3.4	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд ХШҮ хийж ДЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх	Улирал бүр Үндэсний хөтөлбөрүүд, дээд газраас ирсэн тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн ээлжит даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн хурлын протокол хөтлөн, хянаж баталгаажуулан ажилласан бөгөөд тайланг улирал бүр хүргүүлсэн. Үүнд:	
12.	1.3.5.	Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ханган ажиллаж биелэлтийг даргын зөвлөлийн хуралд танилцуулах	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын Алсын Хараа - 2050 Монгол Улсын Шинэ Сэргэлтийн Бодлого МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө Багануур дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 	100
13.	1.3.6.	Байгууллагын үйл ажиллагааны албан хэргийн бүх төрлийн баримт, бичгийг бэлтгэн архивт хүлээлгэн өгөх	<ul style="list-style-type: none"> 2024 он гарсаар манай байгууллагад 172 албан бичиг ирснээс хариутай 68, хариугүй 104 бичиг ирснийг цаг хугацаанд нь чанартай шийдвэрлэсэн. Хариутай, хариугүй бичгийн шийдвэрлэлт 99.51%, нийт бичгийн шийдвэрлэлт 97.40%, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3.63 хоног байгаа нь өмнөх жилийн мөн үеийнхээс 1.05 хоногоор цөөн байна. Мэргэжилтнүүд 	100

			<p>өөрсдөдөө хуваарилагдсан албан бичгээ цаг хугацаанд нь, чанартай шийдвэрлэж байна. Манай байгууллагаас энэ хугацаанд 154 албан бичиг бусад байгууллагуудад илгээгдсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> Албан бичгийн шийдвэрлэлтийн байдлыг 2023 оны жилийн эцсийнхтэй харьцуулбал:  <table border="1" data-bbox="1003 411 1646 829"> <caption>Албан бичгийн шийдвэрлэлтийн байдлыг харьцуулбал</caption> <thead> <tr> <th>Метрик</th> <th>2023 он</th> <th>2024 он</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Нийт ирсэн бичиг</td> <td>~130</td> <td>~170</td> </tr> <tr> <td>Хариутай бичгийн тоо</td> <td>~50</td> <td>~70</td> </tr> <tr> <td>Хариугүй бичгийн тоо</td> <td>~80</td> <td>~100</td> </tr> <tr> <td>Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/Хоног</td> <td>~120</td> <td>~150</td> </tr> <tr> <td>Явуулсан бичиг</td> <td>~70</td> <td>~80</td> </tr> </tbody> </table>	Метрик	2023 он	2024 он	Нийт ирсэн бичиг	~130	~170	Хариутай бичгийн тоо	~50	~70	Хариугүй бичгийн тоо	~80	~100	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/Хоног	~120	~150	Явуулсан бичиг	~70	~80	
Метрик	2023 он	2024 он																				
Нийт ирсэн бичиг	~130	~170																				
Хариутай бичгийн тоо	~50	~70																				
Хариугүй бичгийн тоо	~80	~100																				
Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/Хоног	~120	~150																				
Явуулсан бичиг	~70	~80																				
14.	1.3.7	<p>Архивын үйл ажиллагааг зааврын дагуу хөтлөн явуулж, баримт бичгийг бүрдүүлэх, хадгалах</p>	<ul style="list-style-type: none"> Парк нь 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдөр НИТХ-ын 2015 оны 122 дугаар тогтоолоор байгуулагдсанаас хойш 8 жил үйл ажиллагаа явуулсан тул төрийн архивт баримт шилжүүлэх хуваарийн дагуу бэлтгэлийг хийж, Нийслэлийн Архивын газраас гаргасан 2024 оны 06 дугаар сарын 20-21-ний өдөр баримт шилжүүлэх төлөвлөгөөний дагуу ажилласан. Улмаар, байгууллага үүсэн байгуулагдсанаас хойших үйл ажиллагааны явцад үүссэн, тодорхой хадгалах хугацаа дууссан устгах хэргийн 12 төрлийн 61 нэгж баримт, Төрийн архивт шилжүүлэх байнга хадгалах 152 баримт, Байгууллагын архивын Байнга хадгалах 155 баримт, Түр хадгалах 128 баримт ба 70 жил хадгалах 30, Захирамжлалын цахим баримт 16, Тусгай төрлийн (гэрэл зургийн баримт) 36 нэрийн баримт, Дүрс бичлэгийн 1 баримтын бүртгэлийг гаргаж, байгууллагын Баримт нягтлан шалгах комиссын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02, 06 дугаар сарын 18-ны өдрийн 03 дугаар хурлаар хэлэлцсэн. Эдгээр бүртгэлийг Нийслэлийн Архивын газрын Мэргэжил арга зүйн зөвлөлийн 2 удаагийн хурлаар хэлэлцсэн. Нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК-ын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар, заавар чиглэл, зөвлөмжийн дагуу бүртгэлүүдэд зохих засвар өөрчлөлтийг хийж, бүртгэлүүдийн хамтаар нийслэлийн Архивын газарт хүлээлгэн өгсөн. 	100																		

				<ul style="list-style-type: none"> БНШАЗК-ын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 02 дугаар хурлаар батлагдсан Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын устгах хэргийн жагсаалт дахь устгах хэргийн 12 төрлийн 61 баримтыг шатааж устган, зургийг авч баталгаажуулсан. 	
15.		1.3.8	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн дотоод удирдлагын ERP системийн хэрэгжилтийн дүрэм журмыг мөрдөн ажиллах	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн дотоод удирдлагын ERP системийн дараах дэд цэснүүдийг ашиглаж, системийн хэрэгжилтийн дүрэм журмын дагуу явуулсан.</p> <ul style="list-style-type: none"> Edoc Цаг бүртгэл Хүний нөөцийн удирдлага Өргөдөл, гомдол Нийслэл академи Үндсэн хөрөнгө Олон нийтийн сүлжээ 	100
16.	1.4 Харилцаа, хамтын ажиллагааны удирдлагыг сайжруулна.	1.4.1	Паркийн үйлдвэрийн бүсүүдийн чиглэлд хамаарах салбарын Яамдын дэмжлэг авах, хамтын нягт ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээг авах	<ul style="list-style-type: none"> Паркийн хүнд үйлдвэрийн чиглэлийг тэргүүлэн хөгжүүлэх талаар АҮЭБЯ болон Эрдэнэс Монгол ХХК-тай дараахь чиглэлд хамтран ажилласан: АҮЭБЯ-с Улсын хэмжээнд хүнд үйлдвэрийн паркуудын байршил, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг ЗГ-р батлуулах жагсаалтад БҮТП-г оруулах саналыг хүргүүлэн дэмжүүлж батлуулсан. 2024-2028 онд ЗГ-с хэрэгжүүлэх 14 мега төслөөс БҮТП-т хэрэгжүүлэх тодорхой саналыг салбарын яаманд хүргүүлэн хамтран судалж байна. Паркийн хүнд үйлдвэрийн эрчим хүчний хэрэглээнд шаардлагатай эрчим хүчний хангамжийн 2025-2029 оны төлөвлөлтийг ЭХЯ, ДҮТ ХХК, ЦДҮС ТӨХК-тай хамтран зөвшилцөж, хүнд үйлдвэрийн төслүүдийн ТЭЗҮ-д оруулж байна. ЭМ ХХК-с хэрэгжүүлэхээр зорьж буй 6 мега төслүүдээс Нүүрс химийн үйлдвэрийн цогцолбор төсөл, Гангий төсөл, Кокс болон хүрэн нүүрс гүн боловсруулах төслүүдийг хамтран хэрэгжүүлэх саналыг ЗГХЭГ-т хүргүүлэн тодорхой үр дүнд хүрсэн. 	100
17.		1.4.2	Олон улсын болон дотоодын хөрөнгө оруулагчдын онлайн, танхимын хэлбэрийн форумд оролцох замаар харилцаа хамтын ажиллагааг өргөтгөх	<ul style="list-style-type: none"> 2024 оны 05 сарын 30-ны өдөр зохион байгуулагдсан "Улаанбаатар Олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум 2024" чуулга уулзалтад БҮТП амжилттай оролцон уулзалтаар 350 орчим гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад төслөө танилцуулж, илтгэл тавин, мэдээлэл хүргэж ажилласан. Монгол улсын засгийн газраас 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулга уулзалтад оролцож, төслүүдээ танилцуулсан. 	100
18.		1.4.3	БҮТП-н зүгээс бусад байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ,	<ul style="list-style-type: none"> "Таван толгой түлш" ХХК-тай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд Паркийн хүнд үйлдвэрийн бүсэд байгуулагдахаар төлөвлөгдөж буй Хагас коксны үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах явцад 	

			санамж бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах.	<p>дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. ТЭЗҮ нь хүнд үйлдвэрийн бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд суурилаж байгаа тул гүйцэтгэгч "Евро-ази майнинг" ХХК-ний мэргэжилтнүүдэд холбогдох материал, мэдээлэл, зөвлөмжийг өгсөн. ТЭЗҮ нь 2-р улиралд УУХҮЯ-ны эрдэс баялагийн зөвлөлөөр батлуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> Герман, Казахстаны ферро-силенц-алюмин ФСА хайлшийн үйлдвэрийн төслийг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар даргад танилцуулснаар дэмжиж ажиллахаа илэрхийлсэн бөгөөд энэхүү төслийг НЗД-д танилцуулснаар эдийн засаг дэд бүтцийн асуудал эрхэлсэн зөвлөх Мандуул болон газрын дарга нарт төслийн судалгааг эрчимжүүлэн хамтран ажиллах үүрэг өгсний дагуу БҮТП-ын хүнд үйлдвэрийн бүсэд байгуулахаар судалж буй Багануурын хүрэн нүүрсний олборлолтын явцад үүсэх үнслэг ихтэй хаягдал шороог гүн боловсруулах төмөр цахиурын хайлшийн үйлдвэрийн технологийн болон техникийн түвшинд газар дээр нь үзэж танилцахаар 2024 оны 09.27 ноос 10.03нд Казахстан улсын Алматы хотод байрлах "Ашигт малтмал гүн боловсруулах үндэсний төв" ШУБ-ын урилгаар очиж хамтын ажиллагааны санамж бичиг гэрээ байгуулан хамтын ажиллагааг эхлүүлээд байна. БНХАУ-н Жужань муж-Монголын хөгжлийн нийгэмлэгтэй 2024.11.14-ний өдөр хамтран ажиллах санамж бичиг байгуулж, биелэлтийн хүрээнд БНХАУ-н хөрөнгө оруулагчдыг төмөрийн хүдэр гүн боловсруулах гангийн үйлдвэрийн төсөлд татан оролцуулснаар "Багануур ган" төслийг эхлүүлсэн. Энэ төсөл нь ЗГ-ын 14 мега төслийн гангийн төсөлд хамаарна. 	100
19.		1.4.4	Гадаад, дотоодын түнш харилцагчидтай холбоо тогтоох, хамтрах боломжит чиглэл тодорхойлох, түншлэлийн судалгаа гаргаж шинэчлэх	<p>2024 онд Гадаад харилцааны үйл ажиллагааны хувьд ХБНГУ, БНКУ болон БНХАУ гэсэн 3 улсын хөрөнгө оруулагч түнштэй хамтын ажиллагааг эхлүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> Гадаад томилолт – 1 Зочид төлөөлөгчид – 2 Албан уулзалт – 2 Олон улсын цахим хурал – 2 Сургалт, семинар – 1 Гэрээ, санамж бичиг - 2 	100
20.	2.1 Паркийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээг байгуулна.	2.1.1	Зураг төслийн дагуу Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд шаардлагатай санхүүжилтийн тооцоолол бүхий саналуудыг холбогдох байгуулагад цаг хугацаанд нь хүргүүлэх	<p>Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтын санхүүжилтийг улс, нийслэлийн төсөл хөтөлбөрт тусгуулан шийдвэрлүүлэхээр дараах саналуудыг боловсруулан хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтын шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн жагсаалтад 2024.04.04-ний 58 дугаартай албан бичгээр, Улс болон Нийслэлийн 2025 оны Хөгжлийн төлөвлөгөөний төсөлд 2024.05.16-ны 73 дугаартай албан бичгээр, 	100

			<ul style="list-style-type: none"> ▪ Нийслэлийн ЗДТГ-ын дарга Л.Хосбаярт 2024.06.18-ны 87 тоот албан бичгээр, ▪ Нийслэлийн ЗДТГ-ын Санхүү хөрөнгө оруулалтын газарт 2024.06.18-ны 88 тоот албан бичгээр, ▪ Нийслэлийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулгад шаардлагатай хөрөнгө оруулалтын талаарх эрэмбэлсэн мэдээллийг 2024.05.07-ны 70 дугаартай албан бичгээр, ▪ Монгол Улсын С.Амарсайхан сайдад 2024.11.06-ны 137 тоот албан бичгээр, ▪ МУ-ын ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2024.10.16-ны 126 дугаартай тоот албан бичгээр, ▪ Багануур Дүүргийн Засаг Даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2024.11.14-ны 142 тоот албан бичгээр тус тус дэд бүтцийн хөрөнгө оруулалтын саналыг хүргүүлэв. <p>Манай байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилттэй холбоотой дараах асуудлыг шийдвэрлэх талаар НЗДТГ-н даргын 2024.11.11-ны өдрийн 03/6378 дугаар албан бичиг ирүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 9,911,5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 110/35/10кВ-н 2х16мВА чадалтай үндсэн дэд станц барих ажлыг "Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний 230 дахь заалтад тусган НИТХ-ын 2024 оны 134 дүгээр тогтоолоор батлуулсан. Тус ажлыг 2025 онд ?? хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэх зорилтын дагуу 1048,0сая төгрөгийн санхүүжилтийг Нийслэлийн төсвийн төсөлд тусган, өргөн мэдүүлэхээр бэлтгэл ажил хангагдан хүлээгдэж байна. ▪ Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110 кв-н 6.76 км ЦДАШ-г бүрэн дуусгах арга хэмжээнд 300,0 сая ▪ Паркийн Захиргаа нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын засварын ажлыг "Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний 231 дэх заалтад тусган НИТХ-ын 2024 оны 134 дүгээр тогтоолоор батлуулж 2025 онд 100% гүйцэтгэлтэй хэрэгжүүлэх зорилтын дагуу 700,0 сая төгрөгийн санхүүжилтийг Нийслэлийн төсвийн төсөлд тусган, өргөн мэдүүлэхээр бэлтгэл ажил хангагдан хүлээгдэж байна. ▪ Төмөр, цайр, хөнгөн цагааны нэгдэл ФСА хайлшны үйлдвэр байгуулах төслийн саналыг ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд гадаад эх үүсвэрээс санхүүжүүлж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны дэмжлэгтэй хамтран хэрэгжүүлэхээр тусган Нийслэлийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 	
--	--	--	---	--

				18-ны өдрийн 01/5944 дүгээр албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлээд байна.	
21.		2.1.2	Паркийн үндсэн цахилгаан хангамжийн 110кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах 6,76 км урт агаарын шугамыг барих ажлыг үргэлжлүүлэх	<p>Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын 6.76 км урт өндөр хүчдэлийн агаарын шугамыг барих ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ 2022-2024 онд Нийслэлийн төсвөөс нийт 1,800.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 110кВ-ийн 6.76 км урт ЦДАШ-н бүх суурийн ажил хийгдэж, эхний анкер тулгууруудыг босгож дууссан. ▪ БҮТП-ийн эрчим хүчний дэд бүтцийн трасс замыг ашиглах, Цахилгаан Дамжуулан Агаарын Шугамыг /ЦДАШ/ Хамтарсан хөрөнгө оруулалтаар барих гэрээг 2020 онд 3 жилийн хугацаатай байгуулсан "Месес" ХХК нь гэрээний хугацаанд хөрөнгө оруулалтаа шийдвэрлээгүй үүргээ биелүүлээгүй тул Нийслэлийн Засаг даргын зөвлөх Б.Мөнхбат холбогдох талуудын оролцоотой хурлыг 2024.04.29-ны өдөр зохион байгуулж, тус хурал дээр Месес ХХК-ны хүсэлтээр: <ul style="list-style-type: none"> ○ Паркийн үндсэн 110/35/10кВ, 2*16мВА дэд станцын байршлыг тохиромжтой газарт шилжүүлэх ○ Дэд станцын байршлыг шилжүүлснээр шинээр зураг төслийг дахин боловсруулах зардлыг тус компани 100% хариуцах, ○ Нийслэлийн ЗДТГ-тай төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах ○ Хөрөнгө оруулалтаа 2024.07.01 өдрөөс өмнө 100% оруулж ЦДАШ-н ажлыг дуусгах зэрэг шийдвэрүүд гарсан. ▪ Дээрх шийдвэрийн биелэлтийн хүрээнд паркийн удирдлагын зүгээс Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хандаж 2024.07.05-ны №30/2024 дугаартай техникийн нөхцөл, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газраас 2024.08.23-ний өдрийн №2024/У-18 дугаартай зургийг даалгаврыг тус тус батлуулан авсан. ▪ Харин "Месес" ХХК нь дээрх техникийн нөхцөл, зургийн даалгаврын дагуу шинээр боловсруулах зураг төслийн зардлыг төлөхгүй, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулахгүй бүтээн байгуулалтыг гацаасан тул дахин Нийслэлийн Засаг Даргын өгсөн үүрэг чиглэлийн дагуу Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай ахалж Багануур дүүргийн Засаг дарга С.Даваасүрэн, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, БҮТП, гүйцэтгэгч "Энх өглөө" ХХК, "Месес" ХХК, "Мон Энержи Консалт" ХХК-тай 2024.10.28-ны өдөр хуралдаж дараах шийдвэр гарсан. Үүнд: 	100

				<ul style="list-style-type: none"> ○ Месес ХХК-иас БҮТП-ийн эрчим хүчний хангамжийн Техникийн нөхцөл, ажлын даалгаврын дагуу зураг төсөл боловсруулах зардлыг 100% төлөх, ○ Месес ХХК нь Төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах хүсэлт гаргах, ○ БҮТП-ийн дэд станцын байршлын газрыг Багануур дүүргийн Засаг Даргын саналыг харгалзан сонгох, ▪ 2024.12.03-ны байдлаар НЗДТГ-с "Месес" ХХК-тай байгуулах Төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний асуудлыг Нийслэлийн Хууль эрх зүйн газрын Гэрээ эрх зүйн хэлтэс хариуцан судалж байна. Зураг төсөл боловсруулах зардлын 381,0 сая төгрөгийн нэхэмжлэхийг "Мон энерги Консалт" ХХК-иас "Месес" ХХК-д хүргүүлсэн боловч төлөгдөөгүй хэвээр байна. ▪ Багануур дүүргийн Засаг Даргын санал болгосон газар нь Багануур-Улаанбаатар төмөр замын хамгаалалтын зурвас дагууд байршилтай тул Дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран "Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэг"-т 2024.11.11-ний 141 дугаартай албан бичгээр зөвшилцөх саналыг хүргүүлсэн бөгөөд Тус газраас 2024.11.18-ний 69/146 дугаартай албан бичгээр тус байршилд эрчим хүчний өндөр хүчдэлийн дэд станцын барилга байгууламж барих боломжгүй гэсэн хариу ирүүлсэн. ▪ БҮТП-ийн ерөнхий цахилгаан хангамжийн ЦДАШ-н трасс зам болон дэд станцын байршлыг зураг төсөл боловсруулсан Мон энерги Консалт ХХК нь 2020 онд тодорхойлон Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусган НИТХ-аар батлуулсан бөгөөд төлөвлөлтийн дагуу шийдвэрлэхээр ажиллаж байна. ▪ Хувийн хэвшлийг дэмжин хөрөнгө оруулалт татаж хамтран ажиллахаар Нийслэл болон паркийн зүгээс бүх талын хүчин чармайлт гарган ажиллаж байгаа боловч "Месес" ХХК-ийн талаас үүргээ биелүүлэхгүй, төсвийн хуулийг зөрчих оролдлого удаа дараа гаргаж байгаа нь бүтээн байгуулалтанд сөргөөр нөлөөлж, зорилтот түвшинг хангах нөхцөл бүрдээгүй болно. 	
22.	2.1.3	Төрөөс ҮТП-н хуулийн хүрээнд үзүүлэх хөнгөлөлт, урамшуулал, бусад хууль эрх зүйн орчны талаарх мэдээллийг Хөрөнгө оруулагч нарт тогтмол хүргүүлэх, зөвлөмж өгч ажиллах	Паркийн үйл ажиллагааг сонирхсон гадаад дотоодын хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгчид болон иргэдэд Паркийн нэгж үйлдвэрийг байгуулсанаар Монгол улсаас хууль эрх зүйн таатай дараах нөхцөлүүдийг бүрдүүлж өгсөн байдаг тухай мэдээллийг уулзалын үеэр тайлбарлан таниулан сурталчилж ажилласан ба ХБНГУ, БНКУ болон БНХАУ гэсэн 3 улсын хөрөнгө оруулагч түнштэй хамтын ажиллагааг эхлүүлээд байна.	100	

23.		2.1.4	Паркийн зүгээс Нэгжийн үйл ажиллагааг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээх	www.baganuur-itp.mn байгууллагын албан ёсны цахим хуудсанд Паркийн нэгж дэд гарчиг-т паркийн нэгжийн үйл ажиллагаа болон шинээр нэгжээр элсэхэд шаардлагатай мэдээллийг байршуулан ажиллаж байна.	100
24.		2.1.5	Нэгжийн бүтээгдэхүүн үйлчилгээг форум, үзэсгэлэнд оролцуулан сурталчлах	<p>Паркийн нэгж "Монхимо" ХХК-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг үзэсгэлэн, уулзалтуудаар сурталчлан таниулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> 2024 оны 05 сарын 30-ны өдөр зохион байгуулагдсан "Улаанбаатар Олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум 2024" чуулга уулзалтад амжилттай оролцон 350 орчим гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад төслөө танилцуулж, илтгэл тавин, мэдээлэл хүргэж ажилласан. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар даргад паркийн үндсэн нэгж "Монхимо" ХХК-ийн үйл ажиллагааны тайлан болон тулгамдаж буй асуудлын талаар 2024.04.29нд дэлгэрэнгүй танилцуулсан. 	100
25.	2.4 Өндөр технолог ид суурилсан экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.	2.4.2	Импортыг орлох, экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хүлээн авч, шаардлагатай мэдээллээр ханган зөвлөгөө өгч, хамтран ажиллах	<p>2022 онд судалгааны ажлыг эхлүүлсэн Герман, Казахстаны ферро-силенц-алюмин ФСА хайлшийн үйлдвэрийн төслийг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар даргад танилцуулснаар дэмжиж ажиллахаа илэрхийлсэн бөгөөд энэхүү төслийг НЗД-д танилцуулснаар эдийн засаг дэд бүтцийн асуудал эрхэлсэн зөвлөх Мандуул болон газрын дарга нарт төслийн судалгааг эрчимжүүлэн хамтран ажиллах үүрэг өгсний дагуу БҮТП-ын хүнд үйлдвэрийн бүсэд байгуулахаар судалж буй Багануурын хүрэн нүүрсний олборлолтын явцад үүсэх үнслэг ихтэй хаягдал шороог гүн боловсруулах төмөр цахиурын хайлшийн үйлдвэрийн технологийн болон техникийн түвшинд газар дээр нь үзэж танилцахаар 2024 оны 09.27 ноос 10.03нд Казахстан улсын Алматы хотод байрлах "Ашигт малтмал гүн боловсруулах үндэсний төв" ШУБ-ын урилгаар очиж хамтын ажиллагааны санамж бичиг гэрээ байгуулан хамтын ажиллагааг эхлүүлээд байна. 2. Паркийн хүнд үйлдвэрийн чиглэлээр Төмрийн хүдэр, жонш, хүрэн нүүрс гүн боловсруулах төслүүдийг судлаж, хөрөнгө оруулагч нарт санал хүргүүлэн ажласны үр дүнд БНХАУ-н хөрөнгө оруулагчдын Төмрийн хүдэр жонш хүрэн нүүрс гүн боловсруулах кластер бүтцийн төслийн саналыг хүлээн авч судлаж байна. Энэхүү төслийн үр дүнд гангийн үйлдвэрлэл шинэ шатанд гарч, барилгын бүх төрлийн ган төмрийн хэрэгцээний импортыг орлох, 2000 ажлын байр бий болох НЭЗ-н өндөр ач холбогдолтой байх дүгнэлтийг хийж, ХО-н хүсэлтээр ЭМ ХХК болон ЗГХЭГ-н дарга Учрал сайдад танилцуулсан. Төслийн удирдлагыг ЕС-н аж үйлдвэрлэлийн бодлогын зөвлөх Д.Дашням хариуцаж байгаа бөгөөд хэлэлцээрийн шатанд хүргээд байна.</p>	100

26.	2.5 Зүүн бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд паркийн үйл ажиллагааг чиглүүлнэ.	2.3.1	Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг зүүн аймгийн аж үйлдвэржилтийн бодлоготой уялдуулах, хамтран ажиллах саналуудыг боловсруулан хүргүүлэх	<ul style="list-style-type: none"> Сүхбаатар аймгийн ЗДТГ-тай 2024 оны 6-р сарын 20д уулзалт хийж, Сүхбаатар УТП-н үйл ажиллагаатай танилцсан. Дорнод аймгийн УТП байгуулах тухай саналд туршлага хуваалцах арга хэмжээг зохион байгуулсан. Зүүн 3 аймагуудад хөнгөн үйлдвэрийн паркууд байгуулагдаж байгаа бөгөөд бараа бүтээгдхүүнийг хүнд үйлдвэрийн хэрэгцээнд ашиглаж болох тухай судалгааг хийх хэрэгтэй гэдэг дээр санал нэгдэж бөйгөө. Энэ тухай мөн УИХ-н АҮБХ-д болсон УТП-н хөгжлийн явцын сонгсголд санал оруулсан. 	100
27.	3.2 Орчин үеийн дэвшилтэт техник технологи, шинжлэх ухааны мэдээллийн судалгаа	3.2.1	Олон улс болон өөрийн орны техник технологийн үзэсгэлэнд оролцож байх	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 481 дүгээр тогтоолоор 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарласан. Энэ хүрээнд Бүсчилсэн хөгжлийг эрчимжүүлэх 100 хоногийн ажлын төлөвлөгөөний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газраас "Бүсчилсэн Хөгжил - Хүнд Үйлдвэрийн Үйлдвэрлэл, Технологийн Парк" сэдвийн хүрээнд 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулагдсан уулзалт, хэлэлцүүлэгт газрын дарга болон холбогдох мэргэжилтнүүд оролцож хүнд үйлдвэрийн паркийн бүсчилсэн хөгжилд БҮТП-н үүрэг оролцооны талаар мөн бүсчилсэн Хүнд үйлдвэрлэлийн парк байгуулах салбарын бодлого төлөвлөлтөд БҮТП-г оруулах саналыг танилцуулж дэмжүүлэв. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, "Эрдэнэс Монгол" ХХК хамтран 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан "Үйлдвэрлэл, технологийн паркийн алсын хараа" сэдэвт форумд оролцож: "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Багануурт хэрэгжүүлэх "Нүүрс-химийн цогцолборыг хүнд үйлдвэрийн бүсэд хамтран хэрэгжүүлэх саналыг танилцуулсан. 2024 оны 05 сарын 30-ны өдөр зохион байгуулагдсан "Улаанбаатар Олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум 2024" чуулга уулзалтад БҮТП амжилттай оролцон уулзалтаар 350 орчим гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад төслөө танилцуулж, илтгэл тавин, мэдээлэл хүргэж ажилласан. "Таван толгой түлш" ХХК-тай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд Паркийн хүнд үйлдвэрийн бүсэд байгуулагдахаар төлөвлөгдөж буй Хагас коксны үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах явцад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. ТЭЗҮ нь хүнд үйлдвэрийн бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд суурилагдсан байгаа тул гүйцэтгэгч "Евро-ази майнинг" ХХК-ний мэргэжилтнүүдэд холбогдох материал, мэдээлэл, зөвлөмжийг өгсөн. ТЭЗҮ нь 2-р улиралд УУХҮЯ-ны эрдэс баялагийн зөвлөлөөр батлуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Багануурын хүрэн нүүрсний олборлолтын явцад үүсэх үнслэг ихтэй хаягдал шороог гүн боловсруулах төмөр цахиурын хайлшийн үйлдвэрийг 	100

				<p>технологийн болон техникийн түвшинд газар дээр нь үзэж танилцахаар 2024 оны 09.27 ноос 10.03нд Казахстан улсын "Ашигт малтмал гүн боловсруулах үндэсний төв" ШУБ-ын урилгаар Газрын дарга Ч.Элбэгсайхан, УТА-н ахлах мэргэжилтэн Мөнгөнхуяг нар ЗГ-н төлөөлөгчдийн хамт айлчилж, тус байгууллагаас зохион байгуулсан олон улсын конференцэд оролцож, хамтын ажиллагааны санамж бичиг гэрээ байгуулав</p> <ul style="list-style-type: none"> Монгол улсын засгийн газраас 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулга уулзалтад оролцож, төслүүдээ танилцуулсан. 	
28.		3.2.2	Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний зөвлөлгөөнд оролцох хурал,	ШУТИС-ийн гадаад харилцааны хэлтэстэй паркийн Техник эдийн засгийн үндэслэл болон Хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, паркийн эрдэм шинжилгээ, судалгаа, иноваци төвд инженерүүдийн судалж байгаа Ферро-силенц-алюмин (ФСА) төсөлд Казахстаны эрдэмтэдтэй хамтран хэрэгжүүлэхээр тус тус хамтын ажиллагааг өргөжүүлэн ажилласан.	100
29.	4.1 Санхүүгийн төлөвлөгөө тайлагнал хяналтыг сайжруулж, санхүүгийн чадавхыг нэмэгдүүлнэ.	4.1.1	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах	Байгууллагын үйл ажиллагааны зардалд 449 639 100 төгрөгний төсөв батлагдсаныг зориулалтын дагуу зарцуулан, өр авлага үүсгэхгүй ажилласан ба тайлангийн хуулийн хугацаанд төсвийн гүйцэтгэлийн сар улирлын мэдээ тайланг цаг хугацаанд үнэн зөв тайлагнасан.	100
30.		4.1.2	Шилэн данс цахим хуудсанд байгууллагын санхүүгийн мэдээллийг агуулга стандартын дагуу байршуулж ил тод байдлыг хангах	Шилэн дансны хуулийн хүрээнд уг тайлангийн хугацаанд буюу 2024 он гарсаар олон нийт хяналт тавих, өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, ил тод, нээлттэй ойлгомжтой байх зорилтын хүрээнд байгууллагын 154 төрлийн санхүүгийн баримт бичгийг агуулга стандартын дагуу хөтөлж холбогдох тайлан мэдээллийг www.shilendans.mn сайтад байршуулсан.	100
31.	5.1 Паркийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлнэ.	5.1.1	Паркийн нийгмийн хариуцлагын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх Хөтөлбөрт: -Тогтвортой ажлын байр -Аялал, спортын арга хэмжээ -Ажиллагсдын эрүүл мэндийн үзлэг шинжилгээ гэх мэт асуудлуудыг хэрэгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> Албан хаагчдын амьдралын чанарыг сайжруулах, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд ажлын байрны ая тух, техник хэрэгсэл, шаардлагатай материал хэрэгслийг батлагдсан төсвийн хүрээнд бүрдүүлэн хангаж ажилласан. Байгууллагын нэг албан хаагч 2024 онд амьдрах орчиндоо хувийн байшин шинээр барьж дотоод журмын хүрээнд болон удирдлагын зүгээс 500,0 мянган төгрөгийн барилгын материалын дэмжлэг үзүүлсэн. Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 30 ны өдрийн А/379 дүгээр тушаалаар Хүн амын урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгийн оношлогоо, шинжилгээг 2 жилд нэг удаа байх журмын дагуу байгууллагын 2023 онд хамрагдаагүй албан хаагчдыг эрт илрүүлэг үзлэг оношлогоонд 2024 онд 100% хамруулсан. Байгууллагын албан хаагчдын амьдрах орчныг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд байгууллагын зүгээс мод, бутны үрсэлгээг албан хаагчиддаа өгч амьдрах орчны ногоон 	100

				байгууламжийг нэмэгдүүлэхээр улиас, хайлаас, үхрийн нүд зэрэг модны 10 үрслэгээ, суулгацыг хашаатай 3 албан хаагчид өгч дэмжлэг үзүүлсэн.	
--	--	--	--	---	--



ХЯНАСАН:
 "БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК"
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА *[Signature]* Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
 ЗАХИРГААНЫ АЛБАНЫ *[Signature]*
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.МИЧИД-ЭРДЭНЭ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
 ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *[Signature]* Б.МӨНГӨНХУЯГ